



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**ТҮШИГ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД**

2020-04-30 № ЦА-2020/Ч-НА-32
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Түшиг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Түшиг сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Түшиг сумын Ардчилсан намын хорооны Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Түшиг сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / ⁴..... хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Түшиг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



ӨРХИЙН ӨСӨЛТ НУТГИЙН ХӨГЖИЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд:

Түшиг сумын Ардчилсан намын 2020 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд “**ӨРХИЙН ӨСӨЛТ НУТГИЙН ХӨГЖИЛ**” мөрийн хөтөлбөр.

НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.1.2 Гадаадын их дээд сургуульд жил бүр 2-оос доошгүй шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.

1.1.3 Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/

1.1.4 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд, иргэдийг боломжит сургалтад хамруулахад бодлогоор дэмжиж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн бодлого баримтална.

1.1.5 Сумын ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.1.6 Сумын хүүхэд залуучуудыг гадаад хэлний боловсрол олгох сургалтад шат дараатай хамруулна.

1.1.7 Жил бүр төгсөх ангийн хүүхдүүдийн мэргэжил сонголтод онцгой анхаарч “**Нутгийн оюутан хөтөлбөр**”-г хэрэгжүүлж, Нутгийн зөвлөл, орон нутгийн аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.

1.1.8 Сумын боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргаа зэрэг салбар бүрд төрийн залгамж халааг бэхжүүлэх залуу боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой анхаарч ажиллана.



1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ

1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, өвчлөлийг эрт илрүүлж оношлуулах “**Эрүүл Түшиг**” хөтөлбөр-ийг хэрэгжүүлнэ.

1.2.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хилийн застав, малчдын хүүхдүүдэд жил бүр нарийн мэргэжлийн эмч нараар үзлэг оношилгоо хийлгэж хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч ажиллана.

1.2.3 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.4 Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, үржүүлэх, тариалах үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.5 Эмийн хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.

1.3 Хүн амын өсөлт, хөгжил


1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, эцэг, эхтэйгээ хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж дэмжиж ажиллана.

1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3.3 Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг үргэлжлүүлэн хөгжүүлж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3.4 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3.5 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүлийн байдлыг дэмжиж өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах нөхцөлийг сайжруулна.



1.4 Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

1.4.1 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.

1.5 Нийгмийн хамгаалал

1.5.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

1.5.3 Ахмадын болон хүүхдийн сувилал, зуслан зэрэг бүтээн байгуулалтыг орон нутагт хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана. /Рашаант, Зэлтэр гол орчим/

1.5.4 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

1.6 Соёл, урлаг, спорт

1.6.1 Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж ажиллана.

1.6.2 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулахад анхаарч ажиллана.

1.6.3 Түүх, соёлын, орон нутгаа танин мэдэхүй агуулга бүхий контентыг орон нутагтаа хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

1.6.4 Спорт цогцолбор, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

1.6.5 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.6.6 Сумын хэмжээнд гүйлтийн зам барих ажлыг эхлүүлнэ.

ХОЁР. ХӨГЖИХ БОДЛОГО

2.1. Өсөлтийн бодлого

2.1.1 Сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн эрчимжүүлнэ.

2.1.2 Түшиг суманд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын “Түшиг нутгаа хөгжүүлье” төрийн бус байгууллага байгуулж, хөрөнгө оруулалтын хамтын сан бүрдүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

2.2. Төсөв, санхүү, татварын бодлого

2.2.1 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.

2.2.2 Хуримтлалыг бий болгох сургалтыг зохион байгуулж, ард иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.



2.3. Үйлдвэрлэл

2.3.1 Уул уурхайн салбарыг түшиглэн жижиг, дунд үйлдвэр байгуулах төсөл, хөтөлбөрийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2 Мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангаж, гадагшаа борлуулалт хийх бодлого баримталж ажиллана.

2.3.3 Мах нядалгааны төв, дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжиж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоо, мах, махан бүтээгдэхүүнээр хангах зорилт тавин ажиллана.

2.3.4 Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.

2.3.5 Сумын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангахад онцгой анхаарч ажиллана.

2.3.6 Орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.4 Дэд бүтэц , барилга

2.4.1 Сумын төвийн инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг төр хувийн хэвшлийн оролцоотой бүтээн байгуулалт хийнэ.

2.4.2 Сумын ЗДТГ-ын барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.4.3 "Гудамж" төслийг хэрэгжүүлж явган хүний зам, гудамжны гэрэлтүүлэг, өнгө үзэмжийг сайжруулахад анхаарч ажиллана.

2.4.4 Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайг байгуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.


2.5 Эрдэс баялгийн салбар

2.5.1 Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоход анхаарч ажиллана.

2.6 Аялал жуулчлал

2.6.1 Суманд жуулчид хүлээн авах хүчин чадлыг өсгөж аялал жуулчлалын орлогыг орон нутгийн иргэд хүртдэг “Гэр амралт” хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

2.6.2 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын газрыг шинээр байгуулахад гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.



ГУРАВ. ОРОН НУТГИЙН БОДЛОГО

3.1 “Шинэ хөдөө” хөтөлбөр

3.1.1 Уламжлалт мал, аж ахуйн гаралтай түүхий эд ноос, ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн цэгт бэлтгэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын зах зээл дээр өрсөлдөх үнээр борлуулах боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.1.2 Мал, газар тариалангийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

3.1.3 Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агар техникийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2 Бэлчээр ашиглалт

3.2.1 Малчдын малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.2.2 Сумын бэлчээр ашиглалтын журам, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

3.2.3 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.

3.2.4 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдын бүлэг, хоршоонд эзэмшүүлнэ.

3.3 Газар тариалан

3.3.1 Ногоочдын бүлэг хоршоонд услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

3.3.2 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

3.3.3 Малын тэжээлийн жижиг үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.3.4 Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.3.5 Жимс, жимсгэнийн тариалалтыг өрхийн аж ахуйд тулгуурлан нэмэгдүүлж чанартай, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулах бодлого баримтална.

3.4 Мал аж ахуй

3.4.1 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.

3.4.2 Сумын хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.

3.4.3 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээ хүртээмжийг чанартай болгож хяналтыг сайжруулна.

ДӨРӨВ: ХАРИУЦЛАГАТАЙ ТҮШИГ

4.1 Хуулийн хариуцлага

4.1.1 Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангаж дэмжлэг үзүүлнэ.

4.1.2 Төр, төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгол хийх журамд шилжүүлэхэд анхаарч ажиллана.

4.1.3 Иргэддээ итгэж анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.

4.1.4 Захиргааны ерөнхий хууль, шилэн дансны тухай хууль, нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоотой хяналтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.5 Төрийн албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал нийгмийн асуудлыг шийдэхэд онцгой анхаарч ажиллана.

ТАВ: ЭКО СИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

5.1 Байгалд ээлтэй орчин


5.1.1 Ан амьтан загас гөрөөс, зэрлэг гахай зэрэг амьтдын өсөж үржих боломжийг хангах бодлого баримтална.

5.1.2 Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, хадгалах дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар

гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлэх аймгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.3 Ойжуулах, ойг цэвэрлэх нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж шинэ технологи нэвтрүүлж хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.4 Ой, рашаан, булаг хамгаалсан өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.



ТҮШИГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО